

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 04 сарын 02 өдөр

Дугаар 4/03

Арвайхээр

Ажлын хэсэг байгуулах тухай

Төрийн албаны тухай хуулийн 3 дугаар зүйл 3.1.5, 23.4 дүгээр зүйл, Төрийн албаны зөвлөлийн “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам батлах тухай” 2019 оны 03 дугаар тогтоолын 2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Орон нутгийн өмчийн газрын төрийн захиргааны албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг боловсруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч :Т.Эрдэнэсүрэн (Орон нутгийн өмчийн газрын ажил худалдан авах ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн)

Гишүүдэд: М.Нинжбадгар (Орон нутгийн өмчийн газрын өмчийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн)

А.Баяндүүрэн (Орон нутгийн өмчийн газрын хууль эрх зүй, гэрээний хэрэгжилт, хөрөнгийн мэдээлэл лавлагаа, хөрөнгийн бүртгэл мэдээллийн нэгдсэн програм хариуцсан мэргэжилтэн)

Б.Пүрэвсүрэн (Орон нутгийн өмчийн газрын бараа, зөвлөх Үйлчилгээ, худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн)

Д.Улам-Ундрах (Орон нутгийн өмчийн газрын архив, бичиг хэрэг, нярав)

2. Байгууллагын чиг үүргийн болон ажлын байрны шинжилгээг хийж Орон нутгийн өмчийн газрын төрийн захиргааны албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг журмын дагуу боловсруулахыг ажлын хэсгийн ахлагч (Т.Эрдэнэсүрэн)-д үүрэг болгосугай.

3. Төрийн үйлчилгээний, удирдах болон төрийн захиргааны албаны албан тушаалын тодорхойлолтын бүтэц, агуулга, тухайн албан тушаалд тавигдах тусгай шаардлагыг журмын дагуу хянаж, холбогдох баримт бичгийг бүрдүүлэн 2019 оны 4 дүгээр сарын 05-ны дотор аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтэст хүргүүлэхийг ажлын хэсгийн ахлагч (Т.Эрдэнэсүрэн)-д даалгасугай.

ДАРГА



Н.ГАНБОЛД

177110005